ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДГА-2023/19/НА-СТА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2023 он


Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор: О.Нарангарав

Цахим хаяг: narangarav.o@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.24 № 1-6/279

танай______________-ны №______________-т

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.ТУНГАЛАГТУЯА ТАНАА

***Сөрөг дүгнэлт***

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Хүүхэд асрах болон жирэмсэн амаржсаны чөлөөтэй байгаа 12 хүний 2022 оны 6-р сарын ажил олгогчийн НДШ-ийг тооцож төлөөгүй, энэ нь Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын холбогдох заалттай,
2. Аймгийн БТСГ-тай 2022 оны 9 сараас 4 сарын хугацаатай заал ашиглах гэрээ байгуулан заалны түрээсийн төлбөрт 800.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 “хуулиар зөвшөөрөөгүй бусад зардал санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалттай,
3. Жилийн эцэст 1.7 сая төгрөгийн 96 боодол бичгийн цаас, 1.3 мянган төгрөгийн 27ш принтерийн хор, 1.5 сая төгрөгийн 3000ш сонин, 6.5 сая төгрөгийн шатахууныг нөөцөлсөн, энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6“нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалттай,
4. Төсвийн хөрөнгөөр 4.7 сая төгрөгийн мөнгөн аяга, гарын бэлэг худалдсан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5”төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалттай,
5. Сумын Засаг даргын ашиглах суудлын автомашинаас бусад суудлын автомашинд 15.4 сая төгрөгийн шатахуун зарцуулсан, энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 “Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.
6. Батлагдсан төсвийн зарцуулахдаа засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 0.7 сая төгрөгийн бичиг хэргийн материалыг, 0.5 сая төгрөгийн сургалтын зардлыг, бараа үйлчилгээний бусад зардлаас 16.0 сая төгрөгийн барилгын материал, сэлбэг хэрэгсэл,

тоног төхөөрөмж, материал зэргийг, мэдээлэл сурталчилгааны зардлаас 0.9 сая төгрөгийн худалдаас худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" журамтай нийцээгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргаас эрх шилжин ирсэн 7 төсөл арга хэмжээний ажлыг зохион байгуулж 498.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон 59.4 сая төгрөгийн санхүүжилтийг нийтийг хамарсан ажилд зарцуулан 160 гаруй хүнд олгосон байна.

**Аудитын гол асуудал**

1. Тайлант онд тус байгууллагын нягтлан бодогч нь 4 удаа солигдсон нь байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг цаг хугацаанд нь үнэн зөв тайлагнах нөхцөлийг бүрдүүлэхгүй,
2. Санхүүгийн үйл ажиллагаанд тавих удирдлагын дотоод хяналт хангалтгүй,
3. Байгууллагын 2022 оны санхүүгийн тайланг аудитын байгууллагад ирүүлэхдээ тайлан баланс тэнцээгүй, мөнгөн хөрөнгө, богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдлүүд хасах дүнтэй тоон мэдээлэлтэй байсныг аудитын хугацаанд санхүүгийн байдлын тайланд 702.5 сая төгрөгийн залруулгыг,
4. Авлага өр төлбөрийг бөөн дүнгээр бүртгэн, харилцагч тус бүрээр өр авлагын тооцоог үүсгээгүй, өөр харилцагчийн нэрээр бүртгэж хаадаг, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг зардлын дансыг бууруулан журналын бичилт хийдэг, үнэгүй бараа материал, үндсэн хөрөнгийг өр төлбөр үүсгэн бүртгэсэн, материалд орлого авсан бүртгэлийг өглөг үүсгэн давхар бүртгэсэн зэрэг үр дүнгийн тайлангийн орлого зарлагад нийт 1015.1 сая төгрөгийн залруулгыг,
5. Мөнгөн хөрөнгийн орлого зардлыг гүйлгээг буруу бүртгэн дансны хуулга төсвийн хэлбэлзлээс зөрүүлэн тайлагнасан ба аудитын явцад 543.4 сая төгрөгийн залруулгыг тус тус хийсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн анхан шатны баримтыг он сар дэс дугаарын дагуу үдэж дугаарлаагүй эмх цэгцгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.
Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

## Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **266,427,045.19** | **361,760,063.63** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **-** | **1,557,667.00** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **-** | **1,557,667.00** |
| **31210** | **Төгрөг** | **-** | **1,557,667.00** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 1,557,667.00 |
| **33** | **АВЛАГА** | **29,531,923.98** | **80,511,609.52** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 34,758,585.54 |
| **33500** | **Бусад авлага** | **29,531,923.98** | **45,753,023.98** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 29,531,923.98 | 45,210,889.98 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 542,134.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **6,920,000.00** | **6,920,000.00** |
| **34710** | **Урьдчилгаа тооцоо** | **6,920,000.00** | **6,920,000.00** |
| 34712 | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 6,920,000.00 | 6,920,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **229,975,121.21** | **272,770,787.11** |
| **35100** | **Түүхий эд материал** | **104,863,413.50** | **104,946,713.50** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 101,848,913.50 | 101,848,913.50 |
| 35130 | Эм боох материал | 3,014,500.00 | 3,097,800.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **125,111,707.71** | **167,824,073.61** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 15,780,050.00 | 16,617,950.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 102,257,840.21 | 100,925,799.21 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 84,700.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 777,837.50 | 6,522,877.40 |
| 35460 | Хүнсний материал | - | 14,999.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,295,980.00 | 43,657,748.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **11,519,402,334.15** | **11,279,637,431.09** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **11,519,402,334.15** | **11,279,637,431.09** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **11,164,061,459.07** | **10,968,685,097.57** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,936,300,828.50 | 3,241,757,805.50 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (208,389,314.17) | (255,384,506.45) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 196,344,800.00 | 184,094,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (144,718,130.23) | (139,264,763.51) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 201,684,232.48 | 157,832,333.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (142,562,609.56) | (71,887,732.41) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 114,153,072.84 | 105,813,408.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (67,632,417.36) | (61,741,941.98) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 7,693,928,943.00 | 8,060,143,954.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (981,399,851.99) | (1,718,190,343.03) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,904,578,228.65 | 2,892,425,107.30 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,340,096,523.09) | (1,428,783,223.45) |
| 39217 | Ном | 1,870,200.00 | 1,870,200.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **355,340,875.08** | **310,952,333.52** |
| 39301 | Програм хангамж | 14,686,000.00 | 8,751,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (12,787,124.92) | (5,529,666.48) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 353,442,000.00 | 307,731,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **11,785,829,379.34** | **11,641,397,494.72** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **11,691,514,190.62** | **11,641,397,494.72** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **11,691,514,190.62** | **11,641,397,494.72** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 593,513,848.97 | 593,513,848.97 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 593,513,848.97 | 593,513,848.97 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **10,677,788,659.53** | **10,647,609,373.63** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,139,571,869.22 | 10,756,626,071.53 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 3,538,216,790.31 | (109,016,697.90) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 420,211,682.12 | 400,274,272.12 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **11,785,829,379.34** | **11,641,397,494.72** |

## Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,149,460,491.56** | **2,968,895,396.15** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,413,765,255.30** | **1,036,036,932.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **4,413,765,255.30** | **1,036,036,932.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **88,080.00** | **4,648,367.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 88,080.00 | 4,648,367.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 4,411,486,175.29 | 1,030,869,565.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 2,191,000.01 | 519,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,735,695,236.26** | **1,932,858,464.15** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **714,976,096.00** | **606,718,511.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 612,921,700.12 | 387,804,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 102,054,395.88 | 218,914,311.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,020,719,140.26** | **1,326,139,953.15** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,020,719,140.26 | 1,326,139,953.15 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,610,642,250.05** | **2,952,769,407.39** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,610,642,250.05** | **2,952,769,407.39** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,609,732,250.05** | **2,952,252,107.39** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **718,503,460.72** | **739,601,278.00** |
| 210101 | Үндсэн цалин | 552,183,460.72 | 453,983,447.45 |
| 210102 | Нэмэгдэл | - | 87,208,895.88 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 30,861,142.29 |
| 210104 | Урамшуулал | - | 24,799,071.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 166,320,000.00 | 142,748,721.38 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **98,318,027.00** | **97,648,939.67** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 84,781,427.00 | 61,779,938.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,367,800.00 | 6,449,728.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,696,400.00 | 9,799,070.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 701,400.00 | 2,302,559.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,771,000.00 | 17,317,642.38 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **77,310,597.44** | **82,994,059.14** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,683,952.44 | 8,838,760.44 |
| 210302 | Түлш, халаалт | 60,945,934.00 | 65,402,760.90 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,680,711.00 | 8,752,537.80 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **56,429,518.50** | **52,272,946.54** |
| 210401 | Бичиг хэрэг | 11,925,950.00 | 9,208,577.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,894,835.50 | 22,977,422.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,914,292.00 | 10,987,022.54 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 240,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,785,303.00 | 8,825,495.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 4,565,738.00 | 34,430.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **73,033,455.00** | **4,849,840.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,879,000.00 | 160,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 71,154,455.00 | 4,689,840.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,131,430.00** | **43,120,756.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 7,163,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,131,430.00 | 35,957,756.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **325,000.00** | **6,567,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 325,000.00 | 6,567,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **846,152,142.00** | **774,219,106.64** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 844,084,334.00 | 768,823,521.64 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 525,000.00 | 836,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 238,508.00 | 163,508.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 77,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,282,300.00 | 4,318,377.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **734,528,619.39** | **1,150,977,681.40** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,606,104.02 | 212,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 474,500.00 | 1,803,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 718,448,015.37 | 1,148,961,781.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **910,000.00** | **517,300.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **910,000.00** | **517,300.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 910,000.00 | 517,300.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **3,538,818,241.51** | **16,125,988.76** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **601,451.20** | **125,142,686.66** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 601,451.20 | 125,142,686.66 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **3,538,216,790.31** | **(109,016,697.90)** |

## Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,841,917,559.26** | **1,967,038,755.13** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **88,080.00** | **4,648,367.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **88,080.00** | **4,648,367.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **88,080.00** | **4,648,367.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 88,080.00 | 108,000.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | - | 4,540,367.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,841,829,479.26** | **1,962,390,388.13** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **821,110,339.00** | **636,250,434.98** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 612,921,700.12 | 387,804,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 208,188,638.88 | 248,446,234.98 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,020,719,140.26** | **1,326,139,953.15** |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,020,719,140.26 | 1,326,139,953.15 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,828,142,559.26** | **1,962,011,088.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,828,142,559.26** | **1,962,011,088.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,796,717,903.28** | **1,913,991,798.15** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **653,205,160.82** | **768,788,638.93** |
| 210101 | Үндсэн цалин | 486,885,160.82 | 454,546,782.95 |
| 210102 | Нэмэгдэл | - | 115,832,921.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 30,861,142.29 |
| 210104 | Урамшуулал | - | 24,799,071.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 166,320,000.00 | 142,748,721.38 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **50,279,700.00** | **190,492,128.39** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,743,100.00 | 67,166,794.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,367,800.00 | 84,655,462.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,696,400.00 | 9,799,070.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 701,400.00 | 2,302,559.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,771,000.00 | 26,568,241.19 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **77,310,597.44** | **82,994,059.14** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,683,952.44 | 8,838,760.44 |
| 210302 | Түлш, халаалт | 57,381,384.00 | 65,402,760.90 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,245,261.00 | 8,752,537.80 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **46,376,063.00** | **59,332,577.54** |
| 210401 | Бичиг хэрэг | 9,602,150.00 | 12,611,955.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,157,804.00 | 29,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,195,442.00 | 11,023,122.54 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,180,667.00 | 5,957,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **79,685,093.00** | **4,306,900.00** |
| 210502 | Хоол, хүнс | 77,930,093.00 | 4,306,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **20,045,600.00** | **41,361,605.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 6,875,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,045,600.00 | 34,486,605.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **325,000.00** | **6,567,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 325,000.00 | 6,567,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **840,112,726.00** | **745,041,809.15** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 838,044,918.00 | 740,524,117.15 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 525,000.00 | 786,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 238,508.00 | 163,508.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 77,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,282,300.00 | 3,490,509.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **29,377,963.02** | **15,106,580.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,903,463.02 | 4,947,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 474,500.00 | 10,159,180.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,424,655.98** | **48,019,289.98** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,892,732.00** | **2,982,700.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,892,732.00 | 2,982,700.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **29,531,923.98** | **45,036,589.98** |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 29,531,923.98 | 45,036,589.98 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **13,775,000.00** | **5,027,667.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **13,775,000.00** | **3,470,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **13,775,000.00** | **3,470,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **13,775,000.00** | **3,470,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 13,775,000.00 | 3,470,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(13,775,000.00)** | **(3,470,000.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-** | **1,557,667.00** |
| ***20*** | ***Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл*** | **-** | ***1,557,667.00*** |

## Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **593,513,848.97** | **420,211,682.12** | **7,139,571,869.22** | **8,153,297,400.31** |
| **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 593,513,848.97 | 420,211,682.12 | 7,139,571,869.22 | **8,153,297,400.31** |
| **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **3,538,216,790.31** | **3,538,216,790.31** |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **593,513,848.97** | **420,211,682.12** | **10,677,788,659.53** | **11,691,514,190.62** |
| **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **593,513,848.97** | **420,211,682.12** | **10,677,788,659.53** | **11,691,514,190.62** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 78,837,412.00 | 78,837,412.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 593,513,848.97 | 420,211,682.12 | 10,756,626,071.53 | **11,770,351,602.62** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | -19,937,410.00 | 0.00 | -19,937,410.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -109,016,697.90 | -109,016,697.90 |
| **2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **593,513,848.97** | **400,274,272.12** | **10,647,609,373.63** | **11,641,397,494.72** |

## Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,372,942,100.00** | **1,329,230,653.15** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,372,942,100.00** | **1,329,230,653.15** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,372,942,100.00** | **1,326,247,953.15** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **791,412,000.00** | **768,788,638.93** |
| 210101 | Үндсэн цалин | 435,062,200.00 | 454,546,782.95 |
| 210102 | Нэмэгдэл | 131,094,600.00 | 115,832,921.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 31,535,200.00 | 30,861,142.29 |
| 210104 | Урамшуулал | 17,000,000.00 | 24,799,071.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 176,720,000.00 | 142,748,721.38 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **203,216,600.00** | **190,492,128.39** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 148,271,400.00 | 67,166,794.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,526,800.00 | 84,655,462.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,499,200.00 | 9,799,070.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,446,000.00 | 2,302,559.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,473,200.00 | 26,568,241.19 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **87,186,100.00** | **82,994,059.14** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,658,700.00 | 8,838,760.44 |
| 210302 | Түлш, халаалт | 68,396,300.00 | 65,402,760.90 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,131,100.00 | 8,752,537.80 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 60,004,500.00 | 59,275,077.54 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,612,500.00 | 12,611,955.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 29,500,000.00 | 29,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,752,000.00 | 11,023,122.54 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,900,000.00 | 5,900,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **34,500,000.00** | **34,486,605.00** |
| 210604 | Урсгал засвар | 34,500,000.00 | 34,486,605.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **6,678,700.00** | **6,567,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,678,700.00 | 6,567,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **173,294,200.00** | **168,537,364.15** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 167,885,000.00 | 164,019,672.15 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 790,000.00 | 786,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 450,000.00 | 163,508.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 340,000.00 | 77,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,493,200.00 | 3,490,509.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **16,250,000.00** | **15,106,580.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,000,000.00 | 4,947,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,250,000.00 | 10,159,180.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **2,982,700.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **2,982,700.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 2,982,700.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,372,942,100.00** | **1,326,247,953.15** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,371,942,100.00** | **1,326,139,953.15** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,371,942,100.00 | 1,326,139,953.15 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **1,000,000.00** | **108,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 108,000.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **1,557,667.00** |

## Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **636,250,434.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **636,250,434.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 591,213,845.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **57,500.00** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 57,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **4,306,900.00** |
| 210502 | Хоол, хүнс | 4,306,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,875,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,875,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **579,974,445.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 579,974,445.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **45,036,589.98** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **45,036,589.98** |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 45,036,589.98 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **636,250,434.98** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **636,250,434.98** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 387,804,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 248,446,234.98 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 2,351.9 сая төгрөгийн 4 алдаа илэрснээс аудитын явцад 2,300.3 сая төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

1. Санхүүгийн тайланг дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган баталгаажуулахад дараах алдаа илэрсэн. Үүнд:

- Байгууллагын 2022 оны санхүүгийн тайланг аудитын байгууллагад ирүүлэхдээ тайлан баланс тэнцээгүй, мөнгөн хөрөнгө, богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдлүүд хасах дүнтэй тоон мэдээлэлтэй байсныг аудитын хугацаанд санхүүгийн байдлын тайланд 702.5 сая төгрөгийн залруулгыг,
- Авлага өр төлбөрийг бөөн дүнгээр бүртгэн, харилцагч тус бүрээр өр авлагын тооцоог үүсгээгүй, өөр харилцагчийн нэрээр бүртгэж хаадаг, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг зардлын дансыг бууруулан журналын бичилт хийдэг, үнэгүй бараа материал, үндсэн хөрөнгийг өр төлбөр үүсгэн бүртгэсэн, материалд орлого авсан бүртгэлийг өглөг үүсгэн давхар бүртгэсэн зэрэг үр дүнгийн тайлангийн орлого зарлагад нийт 1015.1 сая төгрөгийн залруулгыг,
- Мөнгөн хөрөнгийн орлого зардлыг гүйлгээг буруу бүртгэн дансны хуулга төсвийн хэлбэлзлээс зөрүүлэн тайлагнасан ба аудитын явцад 543.4 сая төгрөгийн залруулгыг тус тус хийсэн.

2. Сар бүрийн нийт бодогдсон цалин суутгалууд, гарт олгох дүн зэргийг түүвэрлэн нэгтгэж, шилжүүлсэн зардлын дүнтэй нэг бүрчлэн тулган баталгаажуулахад НББ-ийн данс хөтлөлттэй холбоотойгоор НДШ болон ХХАОТ-ын илүү төлөлтийг авлага үүсгээгүй, зардлын бодит гүйцэтгэлийг 4486.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байсныг аудитаар залруулав.

Аудитаар нийт 51.6 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлж, 1 зөвлөмж, 2 албан шаардлага өгсөн.

**5.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

***Илрүүлэлт:***

Байгууллагын шилэн дансанд байршуулбал зохих мэдээллээс 215.2 сая төгрөгийн 65 тушаал шийдвэр хугацаандаа, 231.8 сая төгрөгийн 23 мэдээлэл хугацаа хоцроон, 87.6 сая төгрөгийн 14 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын 2354.7 сая төгрөгийн 120 мэдээллийн 1140.2 сая төгрөгийн 89 мэдээлэл хугацаандаа,1214.5 сая төгрөгийн 31 мэдээлэл байршаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-д “төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийг мэдээлнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Үр дагавар: Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх

***Өгсөн зөвлөмж:***

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг цаг тухай бүрд байршуулах.

**5.2 Албан шаардлага**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зориулалт бус зарцуулалттай холбоотой

***Илрүүлэлт:***

Батлагдсан төсвийг зарцуулахдаа Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 728.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авсан, сургалтын зардалд 500.0 мянган

төгрөгийн төлбөрийг төлж, бараа үйлчилгээний бусад зардлаас 15,994.3 мянган төгрөгийн барилгын материал, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, майхан зэргийг, мэдээлэл сурталчилгааны зардлаас 936.1 мянган төгрөгийн хулдаас худалдан авсан зэргээр зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.
Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” журамтай нийцэхгүй байна.

***Өгсөн албан шаардлага:***

Батлагдсан төсвийн зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй байх

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

***Илрүүлэлт:***

Аймгийн БТСГ-тай 2022 оны 9 сараас 4 сарын хугацаатай заал ашиглах гэрээ байгуулан заалны түрээсийн төлбөрт 800.0 мянган төгрөгийг, төрийн байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээг танилцуулсан сонин хэвлүүлж 1,500.0 мянган төгрөгийг, гарын бэлэг болон мөнгөн аяга авахад 4,711.4 мянган төгрөгийг, сумын Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашинд 15,399.5 мянган төгрөгийн шатахууныг тус тус зарцуулсан байна. Мөн жилийн эцэст бичгийн цаасыг 1,684.0 мянган төгрөгийн 96 боодол, принтерийн хор 1297.0 мянган төгрөгийн 27ш , 1,500.0 мянган төгрөгийн 3000ш сонин, 4380.5 мянган төгрөгийн шатахууныг тус тус нөөцлөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад зардал санхүүжүүлэхийг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.4. "байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.1.6."нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1”үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.7.”хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

***Өгсөн албан шаардлага:***

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруул аагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | То о | Ду н | Тоо | Дүн |
| НББ-ын данс хөтлөлтийн алдаа | 1 | 2,261049.2 | - | - | 1 | 2,261049.2 | 1 | 2,261049.2 | - | - | - | - |
| Цалинтай холбоотой НББ-ийн алдаа | 1 | 39,244.7 | - | - | 1 | 39,244.7 | 1 | 39,244.7 | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **2,300293.9** | **-** | **-** | **2** | **2,300293.9** | **2** | **2,300293.9** | - | - | - | - |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй | 1 | 33,414.8 | - | - | 1 | 33,414.8 | - | - | - | - |
| Зардлын зориулалт бусаар зарцуулсан | 1 | 18,158.4 | - | - | 1 | 18,158.4 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **51,573.2** | **-** | **-** | **1** | **51,573.2** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны хуулийн хэрэгжилт | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **-** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| - | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| Нийт дүн | - | - | - | - | - | - | - | - |